

# БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2024/91/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>	Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл
Өлгий хот	Утас: 70422954 Цахим хаяг: J_aigul@yahoo.com
2024 он	Аудитын менежер: Х.Женисбек
	Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
	Ахлах аудитор: Д.Назгүл
	Утас: 99427301 Цахим хаяг: nazgul_1972@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫ ДҮГНЭЛТ .....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	10
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	13
4.1 Ерөнхий зүйл .....	13
4.2 Материаллаг байдал.....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
4.5.1 Завсрын аудитын талаар.....	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	15
5.1 Төлбөрийн акт.....	15
5.2 Албан шаардлага.....	15
5.3 Зөвлөмж .....	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	16

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1.ХАРААТ БУС АУДИТОРЫ ДҮГНЭЛТ



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgii@audit.gov.mn

САГСАЙ СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН 1 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ С.АРМАНБЕК ТАНАА

2024.02.14 № 99  
танай -ны № -т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой онцлох асуудал гараагүй.

**Аудитын гол асуудал**

Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд анхаарал татах асуудал байхгүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

00402142

# Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

## Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ж.АЙГҮЛ



Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

**Төгрөгөөр**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>108,723,537.00</u></b>	<b><u>174,065,734.82</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	16,299,931.00	61,087,759.82
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	16,299,931.00	61,087,759.82
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	16,299,931.00	61,087,759.82
31211	Төрийн сангийн харилцах	16,299,931.00	61,087,759.82
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	2,260,000.00	2,762,660.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,260,000.00	2,762,660.00
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	408,369.00	-
34100	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон	-	-
34200	Төсөвт байгууллага	408,369.00	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	89,755,237.00	110,215,315.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	89,755,237.00	110,215,315.00
35410	Бичиг хэргийн материал	4,850,000.00	5,695,500.00
35420	Аж ахуйн материал	75,999,280.00	84,073,450.00
35460	Хүнсний материал	8,905,957.00	20,446,365.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>3,089,306,396.07</u></b>	<b><u>3,140,504,242.74</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	3,089,306,396.07	3,140,504,242.74
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	3,053,342,396.07	3,103,140,724.39
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,977,153,118.00	3,002,510,457.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(238,055,438.12)	(280,922,373.88)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	338,944,996.00	271,801,609.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	(248,454,635.33)	(147,242,159.05)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	276,540,990.00	230,416,564.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(177,557,075.48)	(97,063,720.18)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	13,000,000.00	13,000,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	11,986,890.00	11,986,890.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	99,783,551.00	-
39217	Ном	-	98,653,457.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	35,964,000.00	37,363,518.35
39301	Програм хангамж	750,000.00	2,173,239.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(750,000.00)	(773,720.65)
39303	Бусад биет бус хөрөнгө	35,964,000.00	35,964,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>3,198,029,933.07</u></b>	<b><u>3,314,569,977.56</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>1,415,606.00</u></b>	<b><u>45,447,142.94</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	1,415,606.00	45,447,142.94
<b>413</b>	<b>Өглөг</b>	1,415,606.00	45,447,142.94
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	36,791,307.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,415,606.00	945,806.00

Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4136	Бусад өглөг	-	7,710,029.94
41361	Байгууллагад төлөх өглөг	-	7,710,029.94
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,196,614,327.07</b>	<b>3,269,122,834.62</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>3,196,614,327.07</b>	<b>3,269,122,834.62</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,988,658,085.00	1,988,658,085.00
51101	Өмч: - төрийн	1,988,658,085.00	1,988,658,085.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>198,444,429.95</b>	<b>280,596,717.50</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	198,444,429.95	208,088,209.95
51220	Тайлант үеийн үр дүн	-	72,508,507.55
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,009,511,812.12	999,868,032.12
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>3,198,029,933.07</b>	<b>3,314,569,977.56</b>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,740,818,776.00</b>	<b>3,126,450,357.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>89,146,976.00</b>	<b>90,873,057.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>89,146,976.00</b>	<b>90,873,057.00</b>
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	89,146,976.00	90,873,057.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	460,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	89,146,976.00	90,413,057.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,651,671,800.00</b>	<b>3,035,577,300.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>2,352,136,500.00</b>	<b>2,803,444,300.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,352,136,500.00	2,803,444,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>1,620,000.00</b>	<b>-</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,620,000.00	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>297,915,300.00</b>	<b>232,133,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	297,915,300.00	232,133,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,680,761,392.45</b>	<b>3,041,958,030.31</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,680,761,392.45</b>	<b>3,041,958,030.31</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,547,697,403.45</b>	<b>2,948,086,469.31</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,807,901,899.51</b>	<b>2,125,391,814.18</b>
210101	Үндсэн цалин	1,373,623,135.82	1,441,974,005.55
210102	Нэмэгдэл	361,626,533.69	553,219,199.56
210104	Урамшуулал	72,652,230.00	130,198,609.07
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>224,741,531.00</b>	<b>259,713,036.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	153,044,731.00	176,510,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	17,915,100.00	20,903,836.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,331,800.00	16,613,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,620,000.00	4,153,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	35,829,900.00	41,532,200.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>192,701,000.00</b>	<b>229,878,176.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	8,587,647.00	14,531,176.00

Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210302	Түлш, халаалт	184,113,353.00	215,347,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	36,005,010.00
210401	Бичиг хэрэг	-	23,322,300.00
210402	Тээвэр, шатахуун	-	3,470,870.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	9,211,840.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	195,930,688.00	174,086,914.94
210502	Хоол, хүнс	195,930,688.00	174,086,914.94
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	825,000.00	927,027.00
210604	Урсгал засвар	825,000.00	927,027.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	8,566,000.00	9,390,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,566,000.00	9,390,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	117,031,284.94	112,694,491.19
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	39,426,310.00	16,559,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,317,350.00	1,348,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	62,287,624.94	94,786,891.19
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	133,063,989.00	93,871,561.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	133,063,989.00	93,716,714.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	133,063,989.00	93,716,714.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	154,847.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	154,847.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>60,057,383.55</b>	<b>84,492,326.69</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	-	-
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	11,983,819.14
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал-Үндсэн хөрөнгө	-	11,983,819.14
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	(11,983,819.14)
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>60,057,383.55</b>	<b>72,508,507.55</b>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>2,651,671,800.00</b>	<b>3,036,037,300.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>460,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	460,000.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	-	460,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		460,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,651,671,800.00</b>	<b>3,035,577,300.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	2,352,136,500.00	2,803,444,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,352,136,500.00	2,803,444,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	1,620,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,620,000.00	
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	297,915,300.00	232,133,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	297,915,300.00	232,133,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>2,564,384,269.00</b>	<b>2,925,233,971.18</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,564,384,269.00</b>	<b>2,925,233,971.18</b>

Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,471,200,469.00</b>	<b>2,825,381,124.18</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,808,399,000.00	2,088,941,434.18
210101	Үндсэн цалин	1,374,120,235.82	1,405,523,625.55
210102	Нэмэгдэл	361,626,533.69	553,219,199.56
210104	Урамшуулал	72,652,230.49	130,198,609.07
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	225,112,800.00	259,456,100.00
210201	Тэтгэврийн даатгал	153,453,100.00	176,402,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	17,915,100.00	20,765,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,331,800.00	16,603,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,582,900.00	4,153,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	35,829,900.00	41,532,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	192,701,000.00	229,888,476.00
210301	Гэрэл, цахилгаан	8,587,647.00	13,888,600.00
210302	Түлш, халаалт	184,113,353.00	215,999,876.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	182,598,869.00	176,537,307.00
210502	Хоол, хүнс	182,598,869.00	176,537,307.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,100,000.00	2,099,977.00
210604	Урсгал засвар	1,100,000.00	2,099,977.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	8,566,000.00	9,560,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,566,000.00	9,560,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	52,722,800.00	58,897,830.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	37,804,100.00	40,735,730.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,918,700.00	18,162,100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>93,183,800.00</b>	<b>99,852,847.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	93,183,800.00	99,698,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	93,183,800.00	99,698,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	-	154,847.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		154,847.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>87,287,531.00</b>	<b>110,803,328.82</b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)</b>	-	-
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>69,987,600.00</b>	<b>66,015,500.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>69,987,600.00</b>	<b>66,015,500.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	69,987,600.00	66,015,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	69,987,600.00	66,015,500.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(69,987,600.00)</b>	<b>(66,015,500.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	17,299,931.00	44,787,828.82
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		16,299,931.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	16,299,931.00	61,087,759.82

Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Төгрөгөөр
					Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,988,658,085.00	1,009,511,812.12	198,444,429.95	3,144,732,718.17
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,988,658,085.00	1,009,511,812.12	198,444,429.95	3,196,614,327.07
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			9,643,780.00	9,643,780.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,988,658,085.00	1,009,511,812.12	208,088,209.95	3,206,258,107.07
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		-9,643,780.00		-9,643,780.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн			72,508,507.55	72,508,507.55
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,988,658,085.00	999,868,032.12	280,596,717.50	3,269,122,834.62

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	16,299,931.00	16,299,931.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	3,052,259,400.00	2,991,094,624.18
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	3,052,259,400.00	2,991,094,624.18
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,939,987,700.00	2,891,396,624.18
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	2,122,416,500.00	2,088,941,434.18
210101	Үндсэн цалин	1,422,112,700.00	1,405,523,625.55
210102	Нэмэгдэл	570,796,600.00	553,219,199.56
210104	Урамшуулал	129,507,200.00	130,198,609.07
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	265,302,100.00	259,456,100.00
210201	Тэтгэврийн даатгал	180,405,500.00	176,402,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	21,224,200.00	20,765,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	16,979,200.00	16,603,000.00

Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210204	Ажилгүйдлийн даатгал	4,244,900.00	4,153,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	42,448,300.00	41,532,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	231,033,000.00	229,888,476.00
210301	Гэрэл, цахилгаан	12,878,300.00	13,888,600.00
210302	Түлш, халаалт	218,154,700.00	215,999,876.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	176,578,800.00	176,537,307.00
210502	Хоол, хүнс	176,578,800.00	176,537,307.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,100,000.00	2,099,977.00
210604	Урсгал засвар	1,100,000.00	2,099,977.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	12,108,300.00	9,560,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	12,108,300.00	9,560,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	131,449,000.00	124,913,330.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	113,286,600.00	106,751,230.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,162,400.00	18,162,100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	112,271,700.00	99,698,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	112,271,700.00	99,698,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	112,271,700.00	99,698,000.00
<b>13</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	3,036,037,300.00	3,035,882,453.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	2,803,444,300.00	2,803,444,300.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,803,444,300.00	2,803,444,300.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	232,133,000.00	231,978,153.00
132001	Орон нутгийн төсвөөс	232,133,000.00	231,978,153.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	460,000.00	460,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	460,000.00	460,000.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		16,299,931.00
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		61,087,759.82
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>		
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	125	132
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	82	88
620003	Үйлчлэх ажилтан	42	43
620004	Гэрээт ажилтан		

Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

63	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	1,008	1,008
630	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>	1,008	1,008
630001	Төрийн өмчит ЕБС	1,008	1,008
65	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>125</b>	<b>132</b>
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	83	89
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	42	43

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**Төгрөгөөр**

**Нэмэлт төсөв аваагүй.**

**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

**3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь ерөнхий боловсрол олгох үйл ажиллагаа явуулдаг, Боловсрол шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль 2023 онд "Эрдэм мэдлэгээрээ гэрэлт ирээдүйгээ цогцлоон бүтээх шинэ үеийн шилдэг сурагчдыг бэлтгэх" эрхэм зорилгын хүрээнд "Аймгийн түвшний манлайлагч сургууль болох" зорилт дэвшүүлэн ажилласан байна.

**3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь Боловсролын ерөнхий хууль, Бага, дунд боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжуудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Улсын Их хурлаас 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдөр Боловсролын ерөнхий хуулийг шинэчлэн баталсан байна.

Засгийн газрын 2023 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд үнэмлэхгүй хэмжээний өөрчлөлт орсон.

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар "Хөтөлбөр батлах тухай" тушаалаар аккруэл суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Боловсролын ерөнхий газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг Боловсролын ерөнхий газрын дотоод аудитын ажлын хэсэг тайлант онд төлөвлөгөөт шалгалт хийсэн байна.

Сургууль нь дотоод хяналтын нэгжгүй ба захирлын тушаалаар батлагдсан журам, зааврын дагуу төлөвлөгөөт дотоод хяналт шалгалт хийдэг байна.

## Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэль сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн захирлын тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөж ажилласан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 261.4 сая төгрөгөөр буюу 7.6 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	16299.93	61087.76	44787.83
Авлага	2260.00	2762.66	502.66
Урьдчилгаа	408.37	0.00	-408.37
Бараа материал	89755.24	110215.32	20460.08
Үндсэн хөрөнгө	3089306.40	3140504.24	51197.85
<b>Нийт хөрөнгө</b>	<b>3198029.93</b>	<b>3314569.98</b>	<b>116540.04</b>
Өр төлбөр	1415.61	45447.14	44031.54
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3196614.33	3269122.83	72508.51
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>3198029.93</b>	<b>3314569.98</b>	<b>116540.04</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл оны эцэст 61.1 сая төгрөг болж 44.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд: Цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 42.5 сая, , томилолтын зардлаас 0.08 сая, бараа үйлчилгээний бусад зардлаас 2.3 сая, үдийн хоолны зардлаас 12.5 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлаас 2.5 сая төгрөг үлдсэн байна.

Авлага дансанд оны эхэнд 2.3 сая төгрөгийн ажиллагсдаас авах авлагатай байсныг барагдуулаагүй, 0.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Авлагын насжилт 0-3 жил байна.

## Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Бараа материал данс оны эцэст 110.2 сая төгрөг болж оны эхнээс 20.5 сая төгрөгөөр өссөн байна. Төсвийн хөрөнгөөр 329.6 сая төгрөгийн бараа материал худалдан авсан байна. Үүнд: Бичиг хэрэг 5.7 сая, хүнсний материал 20.4 сая төгрөгийн, аж ахуйн материал 84.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,140.5 сая төгрөг болж 51.2 сая төгрөгөөр өссөн байна. Төсвийн хөрөнгөөр 67.5 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, үнэ төлбөргүй 90.4 төгрөгийн үндсэн хөрөнгө хүлээн авсан байна. Аймгийн ИТХ-ын 2023 оны 156 дугаар тогтоолыг үндэслэн элэгдлээ бүрэн нөхсөн, ашиглалтын шаардлага хангахгүй болсон 242.8 сая төгрөгийн хөрөнгийг акталж данс бүртгэлээс хассан байна.

Өр төлбөр дансанд оны эхэнд 0.9 сая төгрөгийн тээвэр шатахууны, 0.5 сая төгрөгийн бусад зардлын өглөгтэй байсан ба оны эцэст хүний орлогын албан татварт 36.7 сая төгрөгийн, үдийн хоолны зардалд 3.4 сая, хөрөнгийн зардлын 1.5 сая, шатахууны зардалд 1.0 сая, бичиг хэргийн зардалд 1.0 сая төгрөгийн өглөгтэй гарсан байна. Энэ нь оны эцэст төрийн сангийн гүйлгээ хаагдахаас өмнө жилийн эцсийн тооцоог хянаж, гүйлгээ хийгээгүйгээс шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 72.5 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 72.5 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны анх батлагдсан төсөв 2,305.8 сая төгрөг байна. үнд: Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,070.0 сая, орон нутгийн төсвөөс 232.1 сая, урьд оны үлдэгдлээс 3.7 сая, нийт 2,305.7 сая төгрөгөөр баталсан байна.

Тайлант оны анх батлагдсан төсвийг 746.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж 3,052.3 сая төгрөгөөр тодотгож баталсан байна

Анх батлагдсан төсвөөс цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 640.8 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 80.1 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 13.0 сая, үдийн хоолны зардлыг 12.7 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж тодотгосон байна.

Төрийн албан хаагчдын цалин 2023 онд үнэмлэхүй хэмжээгээр нэмэгдсэнтэй холбоотой цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлуудыг нэмэгдүүлж тодотгосон байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 11 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,803.4 сая төгрөгийг улсын төсвөөс, 232.1 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,803.4 сая, орон нутгийн төсвөөс 231.1 сая, үйл ажиллагааны орлогоос 0.5 сая, урьд оны үлдэгдлээс 16.2, нийт 3,052.3 сая төгрөгийн төсвөөр үйл ажиллагаа явуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,991.1 сая төгрөг буюу 99.8 хувьтай буюу дансанд 61.1 сая төгрөгийн үлдэгдэл гарсан байна. Төсвийн харилцах дансанд их хэмжээний мөнгөний үлдэгдэлтэй гарсан нь төсвийн төлөвлөлт, хуваарилалттай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Ерөнхий боловсрол				
1	Байр ашиглалтын үйлчилгээ	4,843.30	4,613.55	-229.75	95.26%

Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2	Сургалт семинар	2,421.70	2,360.00	-61.70	97.45%
3	Эрүүл мэндийг дэмжих	4,843.30	3,200.00	-1,643.30	66.07%
4	Үдийн цай хөтөлбөр	112,271.70	99,698.00	-12,573.70	88.80%
5	Дотуур байрны үйлчилгээ	299,535.10	297,314.06	-2,221.04	99.26%
6	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	66,555.60	66,485.30	-70.30	99.89%
7	Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	11,857.60	10,428.32	-1,429.28	87.95%
8	Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр	21,735.00	21,734.30	-0.70	100.00%
9	Боловсролын стандарт, сургалтын хөтөлбөр	1,860,364.90	1,817,668.75	-42,696.15	97.70%
10	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	435,698.20	435,614.20	-84.00	99.98%
11	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	232,133.00	231,978.15	-154.85	99.93%
	Дүн	3,052,259.40	2,991,094.62	-61,164.78	98.00%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд нэмэлт төсөв аваагүй байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 2023 онд батлагдсан төсвийн хүрээнд 329.6 сая төгрөгийн бараа материал, 67.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хилийн цэргийн 0285 дугаар ангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар хэрэгжүүлсэн.

Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

## Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,680.8 сая төгрөгөөс 1 хувиар буюу 26.8 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой шалгахад төлөвлөсөн 30 шалгуур үзүүлэлтээр горим сорил хэрэгжүүлж, хэрэгжилтийг шалгахад алдаа, зөрчил илрээгүй.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 589.4 сая төгрөгийн 32 мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 341.9 сая төгрөгийн 26 мөнгөн гүйлгээ, хөрөнгө зарцуулах 0.8 сая төгрөгийн 1 шийдвэр, өр үүсгэсэн 4.4 сая төгрөгийн 7 шийдвэрийг шилэн дансанд байршуулаагүй байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилт 47%-тай байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа, зөрчил илрээгүй.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлүүд холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

## Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, илүү орон тоотой ажиллуулсан зөрчлүүдэд албан шаардлага, хууль журам зөрчиж олгосон ур чадварын нэмэгдэл, илүү авсан цалин, нэмэгдэл, суутгагдаагүй урьдчилгаа зэрэгт төлбөрийн акт тогтоогдсон байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	3,300.1	1	3,300.1	100%
Албан шаардлага	2	967,478.2	1	951,981.4	50%
Зөвлөмж	0				
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>970,778.3</b>	<b>2</b>	<b>955,281.0</b>	<b>67%</b>

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан байна. Оны эцэст тус байгууллагын нягтлан бодогч шинээр томилогдсон тул Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, ажиллах, илэрсэн зөрчлийг арилгах талаар албан шаардлага өгөв.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 31.3 сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 31.3 сая төгрөгийн алдааг залруулсан.Үүнд: Санхүүгийн үр дүнгийн тайланд тайлант оны үр дүнг 31.3 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг залруулсан.

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын санхүүгийн тайлан гаргах заавар аргачлал, УСНББОУС 1 стандарт, толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 952.7 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрч, дотуур байрны хүүхдийн хоолны норматив, өмнөх аудитын албан шаардлагын хэрэгжилттэй холбоотой илэрсэн зөрчилд 952.7 сая төгрөгийн албан шаардлага өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй.

### 5.2 Албан шаардлага

Аудитаар нийт 952.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгсөн.

1.Нярвын тайлангаар дотуур байрны хүүхдийн хоол хүнсэнд өдөр бүрийн хоолны талоны дүнгээр нийт 38218 хүүхдэд 174.7 сая төгрөгийн хүнсний материал зарцуулсан. Засгийн газрын 2022 оны 498 дугаар тогтоолоор батлагдсан хүүхдийн нэг өдрийн хоолны зардлын нормоор тооцож үзэхэд жилийн дүнгээр батлагдсан нормыг нийтдээ 16.1 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5 дах хэсгийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.5-“батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах“, 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах“, 45 дугаар зүйлийн 45.2-т “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, Засгийн газрын 2022 оны “Хоолны зардлын норматив тогтоох тухай” 498 дугаар тогтоолын 2-т “Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд амьдрах ахлах ангийн нэг суралцагчийн хоногийн хоолны зардлыг 4300 төгрөгөөр, бага, дунд ангийн нэг суралцагчийн хоногийн хоолны зардлыг 4000 төгрөгөөр тус тус тогтоосугай” ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

### Шийдвэрлэсэн нь:

Дотуур байрны хүүхдийн нэг өдрийн хоолны нормативыг мөрдөж ажиллах, цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах талаар албан шаардлага өгөв.

2. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 589.4 сая төгрөгийн 32 мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 341.9 сая төгрөгийн 26 мөнгөн гүйлгээ, хөрөнгө зарцуулах 0.8 сая төгрөгийн 1 шийдвэр, өр үүсгэсэн 4.4 сая төгрөгийн 7 шийдвэрийг шилэн дансанд байршуулаагүй, мэдээлсэн байдлын хэрэгжилт 47% байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 4.1.4-т “хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх”, 5 дугаар зүйлийн 5.1.4-т “мэдээллийг тогтмол шинэчилж байх”, 6 дугаар зүйлийн 6.1-д “энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 6.4-т “энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8-д “..... төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”, 7 дугаар зүйлийн 7.1-д “Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ” гэсэн заалт, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын холбогдох заалтуудыг зөрчсөн байна.

### Шийдвэрлэсэн нь:

Илэрсэн зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх, шилэн дансны хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар албан шаардлага өгөв.

### **5.3 Зөвлөмж**

Зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## **6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

### **Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант үеийн үр дүнг алдаатай тайлагнасан.	1	31,345.0			1	31,345.0	1	31,345.0				

Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дүн	1	31,345.0			1	31,345.0	1	31,345.0				
-----	---	----------	--	--	---	----------	---	----------	--	--	--	--

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дотуур байрны хоолны норматив хэтрүүлсэн	1	16,080.2			1	16,080.2						
<b>Дүн</b>	1	16,080.2			1	16,080.2						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилт 47% байна	1	936,709.6			1	936,709.6		
Дүн	1	936,709.9			1	936,709.9		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
	1	936,709.9						
Дүн								
Нийт дүн					1	936,709.9		